

Дээд боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол, харьяа байгууллагын статистикийн бодлого, төлөвлөлт, өгөгдлийн шинжилгээ, мэдээллийн сангийн зохицуулалт хариуцсан ахлах шинжээч, Дорж Анхзаяа

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Салбарын статистикийн маягт, аргачлалыг боловсронгуй болгох, батлуулах, тайлагнах, түгээх, үйл ажиллагааг удирдлага, манлайллаар хангах, хэрэгжилтэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх							
1	Боловсролын салбарын 2023-2024 оны статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн эмхэтгэл боловсруулж цаасан болон цахим хэлбэрээр олон нийтэд сурталчилна.	Боловсруулсан эмхэтгэл	2023 онд Боловсролын салбарын 2023-2024 оны статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн эмхэтгэлийг хэвлүүлж нийтийн хүртээл болгосон.	Боловсролын салбарын 2023-2024 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийг дүн шинжилгээ хийж, үр дүнгийн эмхэтгэл боловсруулан тархаасан байна.	Боловсрол, шинжлэх ухааны салбарын 2023-2024 оны статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгийн эмхэтгэлийн эх загварыг бэлтгэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан "Монголын Багш нарын 8 дугаар их хурал"-ийг угтан хэвлүүлснээрээ онцлог ажил болсон. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны “Зардал батлах тухай” А/72, 194 тоот тушаалын хүрээнд "Боловсролын салбарын 2023-2024 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхэтгэл"-ийг монгол, англи	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хэл дээр боловсруулан хэвлүүлж, "Монголын Багш нарын 8 дугаар их хурал"-д хүндэт төлөөлөгчөөр уригдсан 21 аймаг, 9 дүүргээс сонгогдсон 1200 багшид тараасан. Мөн эмхэтгэлийн эцсийн үр дүнгийн тайланг УИХ-ын гишүүд, Засгийн газрын гишүүд, бодлогын зарим яамдууд болон бусад бодлого боловсруулагчид, хэрэглэгчдэд тархааж, яамны албан ёсны цахим хаягт байршуулан нээлттэй мэдээлэл авах боломжоор ханган ажилласан.Боловсрол, шинжлэх ухааны салбарын статистикийн мэдээллийн 2023-2024 оны хичээлийн жилийн эмхэтгэлийн нийт 165 хуудас тайланг сүүлийн 4 жилийн динамик мэдээллээр баяжуулан боловсруулж, үр дүнгийн тайланд БШУЯ-ны газар хэлтсүүдээс санал авч тусгаж ажилласан. Тус тайланг нийт 7 бүлгийн хүрээнд 2500 орчим үзүүлэлтээр баяжуулан боловсруулж гаргасан. Бүлэг бүрт салбарын үндсэн үзүүлэлтүүдийг сүүлийн 4 жилийн динамикаар баяжуулан аназик хийж, өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэн дүн шинжилгээ хийж, цаашдын төлөв байдлыг 2030 он хүртэлх динамикаар тооцоолон тайланд тусгасан. 2022-2023 оны хичээлийн		
--	--	--	--	--	--	--	--

					жилийн статистикийн тайланг боловсруулахдаа хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар мэдээллийг хүргэх зорилгоор инфографикаар дүрсэлсэн, мөн салбарын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлтүүдийг тооцон оруулж өгснөөрөө онцлог болсон. Хавсралт: 7 файл		
2	Боловсролын салбарын 2024-2025 оны хичээлийн жилийн статистик мэдээллийг нэгтгэх, тайлагнах үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангана.	Албан ёсны статистик мэдээний тоо	2023 оны гүйцэтгэлээр	Боловсрол, шинжлэх ухааны салбарын 2024-2025 оны албан ёсны статистикийн мэдээллийг батлагдсан нь хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлж, нийтэд тархаасан байна.	Мэргэжлийн болон техникийн боловсрол, Дээд боловсролын салбарын 2023 оны Төсвийн зардлын гүйцэтгэл, хөрөнгийн албан ёсны статистикийн мэдээг 4 маягтаар, 2023-2024 оны төгсөгчийн мэдээг 4 маягтаар, 2024-2025 оны хичээлийн жилийн суралцагч, шинэ элсэгч, багш, ажилтан, орчны албан ёсны статистикийн мэдээг албан ёсны 26 маягтаар тус тус нэгтгэн, хянаж, үр дүнг боловсруулан 2024 оны 11/952, 11/191, 2/1901 тоот албан бичгүүдээр тус тус Үндэсний статистикийн хороонд батлагдсан хугацаанд хүргүүлж, веб болон брошур, дашбоод байдлаар нийтэд тархаасан. Статистикийн мэдээний тайланг боловсруулах үйл ажиллагаад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн, сургууль, дүүргийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					мэргэжилтнүүдтэй 9 удаагийн цахим болон биечилсэн уулзалтыг хийж хамтран ажилласан. Хавсралт: 4 файл		
1.2. Боловсролын салбарын цахимаар үзүүлж буй үйлчилгээний тоо, чанарыг нэмэгдүүлж, лавлагаа, тодорхойлолтын санг нэмэгдүүлнэ.							
3	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж буй үйлчилгээний санг баяжуулж, боловсролын төрийн цахим үйлчилгээн тоог нэмэгдүүлнэ.	Лавлагааны санг баяжуулсан тоо, Цахимаар үйлчилгээ үзүүлсэн тоо, Нэмэгдсэн үйлчилгээний тоо	2023-2024 оны хичээлийн жилд Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй 151,917, ЕБС-д суралцаж буй 776,876, СӨБ суралцаж буй 275,25, НТБТ-д суралцаж буй 5,127 иргэний мэдээллээр лавлагааны сангийн баяжилтыг хийсэн ба 417,850 иргэний дээд боловсролын баримт бичиг баталгаажиж E-Mongolia системийн санд орсон байна.	Лавлагаа тодорхойлолтын сан 2024-2025 оны хичээлийн жилийн мэдээллээр баяжсан байна.	Иргэн Боловсролын байгууллагаас авдаг үйлчилгээг нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээгээр дамжуулан шуурхай авдаг болох бодлогыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан. Боловсролын салбараас авдаг лавлагааны санг өдөр бүр баяжуулж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын авдаг үйлчилгээг Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia.mn/-ээр дамжуулан, цахим хэлбэрээр шуурхай үзүүлж ажиллахад нэгж байгууллагын анхан шатны бүртгэлийг өдөр тутамд хянаж, мэдээллийн үнэн бодит, баталгаатай байдалд хяналт тавьж ажилласан. Үүний үр дүнд 2024-2025 оны хичээлийн жилд Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй 150,282, ЕБС-д суралцаж буй 797,905, СӨБ суралцаж буй 264,818, НТБТ-д суралцаж буй 4,422 иргэний мэдээллээр лавлагааны сангийн баяжилтыг хийсэн ба 460,909 иргэний дээд	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					боловсролын баримт бичиг баталгаажиг E-Mongolia системийн санд орсон байна. Хавсралт: 1 файл		
3.1. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь цахим системд оруулж тайлагнах							
4	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тайлагнах.	Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн тоо	2023 оны биелэлтийн хувь	Холбогдох заалтын хэрэгжилт хангагдсан байна.	Монгол Улсын Их Хурлаар 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан “Дээд боловсролын тухай хууль”-ийн 12.9 дэх хэсэгт “Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг ... олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний байгууллагатай хамтран 2 жил тутам тогтоон олон нийтэд мэдээлнэ.” гэж тусгасан. Энэхүү хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/50 дугаар тушаалаар "Дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэгт 2024 оны 03 сараас 2024 оны 06 сар хүртэл 3 сарын хугацаанд ажиллаж, дээд боловсролын удирдлагын мэдээллийн системийн бүртгэл, мэдээлэл, баяжилтын явц, үнэн бодит байдалд	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хяналт шалгалт хийж, цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хууль, тогтоомж, тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас баталсан захиргааны хэм хэмжээний акт, стандарт, норм нормативын хэрэгжилттэй танилцаж, үнэлэлт дүгнэлт өгч ажилласан. Хавсралт: 1 файл		
5	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хугацаанд нь тайлагнасан байна. Хэрэгжилт хангагдсан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүний хөгжлийн бодлого хэсгийн 2.3.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ гэсэн заалтын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээний нийт 8 шалгуур үзүүлэлтийг боловсролын салбарын 2023-2024 оны хичээлийн жилийн захиргааны статистикийн мэдээлэлд үндэслэн жилд 2 удаа буюу 2024 оны 01 сар, 2024 оны 06 сард тус тус тооцож, гүйцэтгэлийн үр дүнг хянан Боловсролын нэгдсэн бодлогын газар болон ХШҮДАГ-т тус тус хүргүүлэн мэдээллээр ханган ажилласан. Мөн тус хөтөлбөрийн 2.4.Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан үндэсний төвүүдийг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					байгуулах замаар нөөцийг төвлөрүүлж, эрдэм шинжилгээний ажлын зардлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухааны үр ашгийг нэмэгдүүлсэн байна гэсэн заалтын нийт 5 шалгуур үзүүлэлтийг ШУТ-ийн салбарын 2023, 2024 оны захиргааны статистикийн мэдээлэлд үндэслэн үр дүнгийн гүйцэтгэлийг тооцож, ХШҮДАГ-т 2024 оны 06 дугаар сард хүргүүлэн мэдээллээр ханган хамтран ажилласан. Хавсралт: 1 файл		
6	Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах.	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2022 оны тайлан	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын боловсролын салбарын нийт 19 шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийн үр дүнг 2023 оны гүйцэтгэлээр тооцож, 2018-2022 оны мэдээллийг дахин нягтлан хянаж, холбогдох тайлбарын хамт 2024 оны 06 сард Боловсролын яамны ХШҮДАГ-т болон 2024 оны 1а/2976 тоот албан бичгээр Үндэсний статистикийн хороонд хугацаанд нь хүргүүлэн хамтран ажилласан. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын боловсролын салбарын нийт 19 шалгуур үзүүлэлтийн 2023	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					оны гүйцэтгэлийн үр дүнг ҮСХ-ны мэдээллийн сангийн "Алсын хараа-2050" цэсэд байршуулан нийтэд мэдээлсэн. Хавсралт: 3 файл		
7	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах нийт 20 шалгуур үзүүлэлтийг боловсролын салбарын 2023-2024 оны хичээлийн жилийн захиргааны статистикийн мэдээлэлд үндэслэн жилд 2 удаа буюу 2024 оны 01 сар, 2024 оны 06 сард тус тус тооцож, гүйцэтгэлийн үр дүнг хянан баталгаажуулж, хугацаанд нь Боловсролын нэгдсэн бодлогын газар болон ХШҮДАГ-т тус тус хүргүүлэн мэдээллээр ханган ажилласан. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

3.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах

8	Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	Мэдээллийн тоо, хэрэгжилтийн хувь	2023 оны байршсан мэдээлэл	1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. 2. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан боловсролын салбарын "Нээлттэй өгөгдлийн жагсаалт"-ын дагуу 113,114,115,116,117,118 дугаар хэсэгт заасан нээлттэй өгөгдлийг боловсролын салбарын 2023-2024 оны хичээлийн жилийн албан ёсны	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ
---	---	-----------------------------------	----------------------------	---	---	---	--

				байршуулсан байна.	статистикийн нийт 42 үзүүлэлтээр баяжуулан, яамны нээлттэй өгөгдлийн цахим хуудаст 2024 оны 11 сарын 15-ны дотор буюу хугацаанд нь байршуулж, Боловсролын яам болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Та бүхэн дараах холбоосоос үзнэ үү. https://moe.gov.mn/statistics-industry?category_id=11397 Хавсралт: 2 файл	сар, 12-р сар	төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--------------------	--	---------------	---

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль,	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль,	-	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль,	1. БШУЯ-наас “Боловсрол – Их Өгөгдөл (Big Data) – AI (Artificial Intelligence)” сэдэвт Боловсролын салбарын их өгөгдлийн шинжилгээний цахим системийн нээлтийн арга хэмжээг 2024 оны 2-р сарын 29-ний өдөр зохион байгуулах ажлыг хариуцан ажилласан. БШУЯ-наас Боловсролын салбарын дижитал	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн

дагалдан гарсан хууль тогтоомжийг судалж үйл ажиллагаан даа мөрдлөг болгон хэрэглэх	дагалдан гарсан хууль тогтоомжийг судалж үйл ажиллагаан даа мөрдлөг болгон хэрэглэх		дагалдан гарсан хууль тогтоомжийг судалж үйл ажиллагаан даа мөрдлөг болгон хэрэглсэн байна	шилжилтийн санаачилгыг өргөн хүрээнд хэрэгжүүлж буй бөгөөд тус нээлтийн үеэр Боловсролын салбарын стратегийн болон өдөр тутмын шийдвэр гаргах процессод өгөгдөл-мэдээллийн шинжилгээ буюу дата аналитикийг ашиглах түүнчлэн боловсролын салбарт өгөгдөл мэдээлэл, нотолгоонд суурилсан бодлого төлөвлөлтийг нэвтрүүлэх зорилго бүхий цахим систем хөгжүүлснийг олон нийтэд танилцуулсан. Энэхүү санаачилгыг цаашид илүү баяжуулах, салбарын өгөгдлийн шинжилгээг хөгжүүлэх зорилгоор "Монгол Улсын Их Сургуулиас санаачлан "Тинк Про" ХХК-тай хамтран зохион байгуулсан "Microsoft Power BI" болон "Tableau" платформын сургалтад 2024 оны 10 сард хамрагдаж бизнес аналитик шийдэлд суралцаж, дата өгөгдлийг боловсруулах, их өгөгдөлд дүн шинжилгээ хийх, оновчтой шийдвэр гаргалтын ур чадварт суралцсан. Тус сургалтуудад суралцсаны үр дүнд боловсролын салбарын 2023-2024 оны хичээлийн жилийн статистикийн мэдээлэл болон Дээд боловсролын эрэлттэй тэргүүлэх мэргэжлийн хүний нөөц, хөдөлмөрийн зах зээлийн шинжилгээ бүхий ухаалаг дашбордыг хөгжүүлж албан хэрэгцээнд шийдвэр гаргалтад ашиглах боломжийг бүрдүүлсэн. 2. ЮНЕСКО-гоос зохион байгуулсан боловсролын салбарын статистикчдийн хуралд 2024 оны 02 сарын 05-09-ны өдрүүдэд оролцож, өөрийн улсын ТХЗ-ын үзүүлэлтийн өнөөгийн байдал, цаашдын зорилтын талаар танилцуулж, мэдээлэл солилцож, чадавхажсан. 1. Боловсролын статистик мэдээлэл https://app.powerbi.com/groups/me/reports/aa3f0c5b-209c-4561-b414 2. Эрэлттэй/тэргүүлэх мэргэжлээр суралцагчийн шинжилгээ - https://public.tableau.com/app/profile/ankhaa.d/viz/2035byAZ/2035HRDEMAND 3. 2035 он хүртэлх хүний нөөцийн шинжилгээ - https://public.tableau.com/app/profile/ankhaa.d/viz/2035byAZ/2035HRDEMAND Хавсралт: 1 файл	р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	даргын үнэлгээ: 100%
---	---	--	--	---	--	----------------------

ТАЙЛАН ГАРГАСАН:

Дээд боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол, харьяа байгууллагын статистикийн бодлого, төлөвлөлт, өгөгдлийн шинжилгээ, мэдээллийн сангийн зохицуулалт хариуцсан ахлах шинжээч, Дорж Анхзаяа /...../

Огноо: